



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Их наадмын заавар батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 467 дугаар тогтоол, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 511 дугаар тушаалыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Монголын Бүх Ард түмний спортын XIV их наадмыг зохион байгуулах нэгдсэн зааврыг хавсралтаар баталсугай.

2. Их наадмын бэлтгэл ажлыг ханган дэд ажлын хэсгүүдийг байгуулан ажиллуулах, дүн мэдээг нэгтгэн шуурхай мэдээлэх, тэмцээний санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу шуурхай шийдвэрлэх, медаль хүртсэн тамирчдад олгох мөнгөн шагналын зардлыг төсвийн багцдаа зохицуулан олгох талаар арга хэмжээ авахыг Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн захирал /П.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Нийтийн Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Х.Бакытжан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ЛАМБАА

080033

Төрийн нарийн бичгийн даргын
2016 оны 01 сарын 13 өдрийн
10 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ СПОРТЫН XIV ИХ НААДМЫН НЭГДСЭН ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэс

Нийгэм соёлын болон хүний бие бялдрын хөгжил, эрүүл аж төрөх хэв маягийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хүн амын дунд зохиох биеийн тамирын ажил, үйлчилгээний төрөл, хэлбэр, хүрээг өргөтгөх, чанар хүртээмжийг сайжруулах явдал чухал болоод байна. Өнөөгийн дэлхийн чиг хандлага нь спортын арга хэмжээгээр дамжуулан спортоор хичээллэгчдийн хүрээг нэмэгдүүлэх, ажил амьдралын чанарыг сайжруулахад чиглэгдэж байна.

Монголын бүх ард түмний спортын XIV их наадам нь нийтийн биеийн тамир, нийтлэг хөгжсөн спорт болон их спортын төрлүүдийг хөгжүүлэх, биеийн тамир, спортын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, орчин нөхцлийг сайжруулахад чухал хөшүүрэг, түлхэц болно.

Хоёр. Зорилго

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хуулийн 16.1, Засгийн газрын 2015 оны 467 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2014 оны 27, 2015 оны 144 дүгээр зарлигуудыг тус тус үндэслэн биеийн тамир, спортын хөгжлийг эрчимжүүлэх болон нийтийн биеийн тамир, их спортын хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлоход Монголын бүх ард түмний XIV спортын их наадам (цаашид Их наадам гэх)-ын зорилго оршино.

Гурав. Зорилтууд

- 3.1. Хүн амын биеийн тамир, спортын үйл ажиллагаанд өргөнөөр хамруулах;
- 3.2. Биеийн тамир, спортын тэмцээнийг өндөр түвшинд зохион байгуулахад спортын холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- 3.3. Өндөр зэрэгтэй тамирчдын спортын ур чадварыг дээшлүүлэх ба Олимпийн наадам, дэлхий, тив, олон улсын спортын тавцанд өрсөлдөх шилдэг авъяастай тамирчдыг илрүүлэн, залгамж халааг бэлтгэх;

Дөрөв. Удирдлага зохион байгуулалт

- 4.1. Их наадмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүргийг улсын хэмжээнд Эрүүл мэнд, спортын яам, Биеийн тамир, спортын хөгжлийн төв, спортын холбоодоос бүрдсэн их наадмын Зохион байгуулах хороо байна.

- 4.2. Аймаг, нийслэлийн дүүрэг, салбарын байгууллага нь Зохион байгуулах хороог байгуулан харьяалах орон нутаг, салбартаа аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангах, хяналт тавих, мэдээллээр хангах, тайлагнах, үр дүнг тооцох асуудлыг хариуцна.
- 4.3. Их наадамд аймаг, дүүрэг, их, дээд сургууль, салбар, аж ахуйн нэгж, байгууллага түшиглэн байгуулагдсан спортын хороо, клуб болон төрөлжсөн спортын клубүүд бие даан оролцоно.
- 4.4. Их наадамд бие даан оролцох бүх шатны байгууллагууд их наадамд оролцохын өмнө олон нийтийг хамарсан анхан шатны тэмцээнүүдийг зохион байгуулж тайлан мэдээг их наадмын Зохион байгуулах хороонд ирүүлсэн байна.
- 4.5. Их наадмын тэмцээнүүдийг их наадмын Зохион байгуулах хороо тухайн спортын төрлийн холбоодтой хамтран зохион явуулна.
- 4.6. Их наадамд 1 тамирчин өвөл, зуны спортын тус бүр нэг төрөлд оролцож болно.
- 4.7. Их наадмын нээлт, хаалтын арга хэмжээг их наадмын Зохион байгуулах хорооны гишүүдийн хурлаар хэлэлцэж хугацааг шийдвэрлэнэ.

Тав. Спортын төрөл, хугацаа

- 5.1. Их наадмын тэмцээнүүдийг тухайн спортын төрлийн улсын аварга шалгаруулах тэмцээнтэй хамтатган зохион байгуулж явуулна.
- 5.2. Их наадмын спортын төрлүүдийг өвөл, зун, паралимпийн спортын төрлүүдээс нийтийг хамарсан байдал, хичээллэгчдийн тоо, хөгжлийн цар хүрээ, олимпын наадамд оролцох эрх авсан зэргийг үндэслэн тогтооно.
- 5.3. **Өвлийн спортын төрөл:**
1. Цана
 2. Тэшүүр
- 5.4. **Зуны спортын төрөл:**
- 5.4.1. Аэробик
 - 5.4.2. Байт харваа
 - 5.4.3. Бокс
 - 5.4.4. Буудлага
 - 5.4.5. Волейбол
 - 5.4.6. Даам
 - 5.4.7. Дугуй /Уулын/
 - 5.4.8. Жүдо
 - 5.4.9. Сагсан бөмбөг
 - 5.4.10. Таеквондо /олимпын/
 - 5.4.11. Хөл бөмбөг
 - 5.4.12. Хөнгөн атлетик
 - 5.4.13. Хүндийн өргөлт
 - 5.4.14. Чөлөөт бөх
 - 5.4.15. Шатар
 - 5.4.16. Ширээний теннис
- 5.5. **Пара спортын төрөл**
- 5.5.1. Пара Жүдо
 - 5.5.2. Пара Хөнгөн атлетик.

5.6. Их наадмын тэмцээний төрөл тус бүрийн зааврыг тухайн төрлийн олон улсын холбооны дүрмийн дагуу их наадмын нэгдсэн заавартай уялдуулан батлан гаргаж зохион байгуулна. Жич:Бокс, Жүдо бөх, Чөлөөт бөхийн төрлийн тэмцээнүүд нь тухайн спортын холбооноос гаргасан зааврын дагуу их наадмын хүрээнд зохион байгуулагдах бөгөөд холбооноос зааврын дагуу мандат олгоно.

5.7. Их наадмыг 2016 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 08 дугаар сарын 28-ны хооронд зохион байгуулж тэмцээний дүн мэдээг нэгтгэх, мэдээлэх, их наадмын нэгдсэн дүнг олон нийтэд сурталчлах үүргийг Зохион байгуулах хороо хүлээнэ.

Зургаа. Спортын төрлийн зай, жин, ангилал, багийн бүрэлдэхүүн, шигшээ тэмцээн зохиогдох хугацаа, байршил

№	Спортын төрөл	Жин, зай, төрөл	Хугацаа	Байршил
Өвлийн спортын төрөл				
1.	Цана	<i>Эрэгтэй:</i> 1,5км, 15км, 20км,буухиа 3х10км <i>Эмэгтэй:</i> 1,5км, 10км, 15км, буухиа 3х5км	III/05-06	УБ хот, Скай ресорт
2.	Тэшүүр	<i>Эрэгтэй:</i> 500м, 1000м, 1500м, 5000м, <i>Эмэгтэй:</i> 500м, 1000м, 1500м, 3000м, /эрэгтэй -2, эмэгтэй-2, дасгалжуулагч-1 /	III/04-06	Хандгайт цанын бааз
Зуны спортын төрөл				
3.	Аэробик	<i>Ганцаарчилсан эрэгтэй-1, эмэгтэй-1, холимог хос-1 /эр-1, эм-1/, Степний баг -1/ хүйс хамаарахгүй 8 хүн/</i>	IV/16-17	УБ хот СТО
4.	Бокс	<i>Эрэгтэй:</i> 46-49кг, 52кг, 56кг, 60кг, 64кг, 69кг, 75кг, 81кг,-91кг, +91кг <i>Эмэгтэй:</i> 46-48кг, 51кг, 54кг, 57кг, 60кг, 64кг,69кг, 75кг	I/10-17	УБ хот Буянт ухаа спортын ордон
5.	Буудлага	<i>Эрэгтэй:</i> БКВ-6, БКГ-6, ХВ-6, ХГ-6, БҚД-9 <i>Эмэгтэй:</i> БКВ-9, БКГ-5,ХВ-4, БКВ-5, ХГ-4	VI/06-11	УБ хот Аварга клуб
6.	Байт харваа	<i>Эрэгтэй:</i> Хувь, баг <i>Эмэгтэй:</i> Хувь, баг	VIII/18-21	УБхот Төв цэнгэлдэх
7.	Волейбол	<i>Эрэгтэй:</i> баг 12 тоглогч <i>Эмэгтэй:</i> баг 12 тоглогч	V/07-15	УБ хот СТО
8.	Жүдо бөх	<i>Эрэгтэй:</i> 60кг, 66кг, 73кг, 81кг, 90кг, -100кг, +100кг <i>Эмэгтэй:</i> 48кг, 52кг, 57кг, 63кг, 70кг, -78кг, +78кг	I/08-09	Орхон аймаг
9.	Чөлөөт бөх	<i>Эрэгтэй:</i> 57кг, 61кг, 65кг, 70кг, 74кг, 86кг, 97кг 125кг <i>Эмэгтэй:</i> 48кг, 53кг, 55кг, 58кг, 60кг 63кг, 69кг, 75кг,	I/9-11	УБ хот Буянт ухаа спортын ордон
10.	Хөнгөн атлетик	<i>Эрэгтэй:</i> 100м, 200м, 400м, 800м,1500м, 5000м, 10000м, уртын харайлт, бөөрөнцөг, зээрэнцэг, 4х100м, 4х400м, 3-ын харайлт <i>Эмэгтэй:</i> 100м, 200м, 400м, 800м, 1500м, 5000м, 10000м, бөөрөнцөг, зээрэнцэг, 4х100м, 4х400м, уртын харайлт, 3-ын харайлт	VII/22-24	УБ хот /Налайх/
11.	Хүндийн өргөлт	<i>Эрэгтэй:</i> 56кг, 62кг, 69кг, 77кг, 85кг, 94кг, 106кг, +105кг <i>Эмэгтэй:</i> 48кг, 53кг, 58кг, 63кг, 69кг, -75кг, +75кг	III/4-6	Сүхбаатар аймаг
12.	Шатар	<i>Эрэгтэй:</i> Ганцаарчилсан <i>Эмэгтэй:</i> Ганцаарчилсан	II/16-25	Завхан аймаг
13.	Сагсан бөмбөг	<i>Эрэгтэй:</i> Баг 10 тоглогч <i>Эмэгтэй:</i> Баг 10 тоглогч	VI/12-19	УБ хот СТО

14.	Ширээний теннис	Эрэгтэй: Ганцаарчилсан, баг Эмэгтэй: Ганцаарчилсан, баг	V/11-15	УБ хот "Оч" клуб
15.	Дугуй /уулын дугуй/	Эрэгтэй: Кросс коаунтри 30км, Марафон 50км Эмэгтэй: Кросс коаунтри 20км, Марафон 30км	VI/11-12	УБ хот Хүй долоон худаг
16.	Хөл бөмбөг	Эрэгтэй: Баг 15 тоглогч	VIII/17-26	УБ хот
17.	Таеквондо	Эрэгтэй: 50кг, 54кг, 58кг, 63кг, 68кг, 74кг, -80кг, +80кг Эмэгтэй: 46кг, 49кг 53кг, 57кг, 62кг, 67кг	V/17-18	УБ хот СТО
18.	Даам	Эрэгтэй: Ганцаарчилсан Эмэгтэй: Ганцаарчилсан	V/20-28	УБ хот
Пара спортын төрөл				
19.	Пара жүдо бөх	Эрэгтэй: 60кг, 73кг, -90кг,+90 кг Эмэгтэй: 52кг, 63кг, -70кг, +70кг,	IV/14-15	УБ хот СТО
20.	Пара хөнгөн атлетик	Эрэгтэй: Гүйлт Т11-хараагүй /5000м/ Гүйлт Т12-13 – сул хараатай /5000м/ Гүйлт Т46 – гарын тайралт /5000м/ Гүйлт Т 53-54 – тэргэнцэртэй /800м/ Зээрэнцэг F37/38 Зээрэнцэг F 55/56 Зээрэнцэг F 57/58 Бөөрөнцөг F 40-41 Эмэгтэй: Гүйлт Т11 - хараагүй /800м/ Гүйлт Т12 - сул хараатай /1500м/ Гүйлт Т 53-54 - тэргэнцэртэй /400м/ Зээрэнцэг F37/38 Зээрэнцэг F 55/56 Зээрэнцэг F 57/58 Бөөрөнцөг F 40-41	VI/10-12	УБ хот Төв цэнгэлдэх хүрээлэн

Долоо. Мэдүүлэг хүлээн авах хугацаа, бүрдүүлэх материал, нас

7.1. Их наадмын тэмцээнд оролцох баг тамирчдын мэдүүлгийг төрөл тус бүрийн тэмцээний техникийн зөвлөгөөн дээр Зохион байгуулах хорооноос томилогдсон мандатын комисс, эх материалтай тулган хянаж тэмцээнд оролцуулна.

7.2. Мэдүүлэгт багийн дасгалжуулагч, тамирчны овог нэр, нас, хүйс, регистрийн дугаар, оролцох спортын төрлийн зай, жин, үндсэн байгууллага, ажилладаг газар, клуб, эрүүл мэндийн дүгнэлтийг гарган тухайн харьяа байгууллагын дарга, захирал, эмчийн гарын үсэг, тамгаар баталгаажуулсан байна.

7.3. Тамирчин, дасгалжуулагчын эрүүл мэнд, амь настай холбоотой хүндрэлтэй асуудал гарсан тохиолдолд холбогдох зардлыг мэдүүлэг гаргасан байгууллага хариуцна.

7.4. Хэрэв овог нэр, нас, харьяалалын болон бусад зөрчил илэрсэн тохиолдолд тухайн тамирчин, спорт тоглоомын төрлийн багийг тэмцээнээс хасч, тэмцээний шагнал, амжилтыг хүчингүйд тооцон, дараагийн тамирчин, багт мөнгөн шагналыг олгоно.

7.5. Их наадамд оролцох тамирчдын насны ангилал нь тухайн спортын төрлийн олон улсын холбооны дүрэмд нийцсэн байна.

Найм. Төсөв санхүүжилт

8.1. Их наадмын хүрээнд зохион байгуулсан анхан шатны тэмцээний зохион байгуулалтын зардал, наадмын тэмцээнд оролцох баг, тамирчдын байр, хоол, унааны болон бусад зардлыг чиг үүргийн дагуу аймаг, дүүргийн их наадмын Зохион байгуулах хороо, ЗДТГазар, Нийгмийн халамжийн хэлтэс, Биеийн тамир, спортын газар, хороод, их дээд сургууль, харъяа байгууллага, клуб хариуцна.

8.2. Их наадмын тэмцээнийг зохион байгуулж байгаа спортын холбоодын үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

Ес. Шагнал, урамшуулал

9.1. Их наадмаас медаль хүртсэн тамирчин, багийн нийлбэр дүнгээр эхний 3 байрт шалгарсан дасгалжуулагчид Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 64 дүгээр тогтоолын дагуу мөнгөн шагнал олгоно.

9.2. Их наадамд оролцогч нийт байгууллагуудыг өвлийн спорт болон пара спортын төрлүүдээс авсан медалийн чанараар нь тус бүр эхний 5 байр эзлүүлж Их наадмын өргөмжлөл, дурсгалын цом, медалиар шагнаж урамшуулна.

9.3. Зуны спортын төрлүүдээс авсан медалийн чанар, тоог харгалзан их наадамд оролцогч нийт байгууллагаас эхний 10-н байрт шалгарсан байгууллагыг Их наадмын өргөмжлөл, дурсгалын цом, медалиар шагнаж урамшуулна.

9.4. Их наадмын тэмцээнийг амжилттай зохион байгуулсан 10 спортын холбоог шалгаруулан их наадмын өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын медалиар шагнаж, урамшуулна.

МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ СПОРТЫН ХИВ ИХ НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО